



**ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН .11. ДҮГЭЭР
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 07

Хэрлэн сум

**Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний
хэрэгжилтийг дүгнэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.16 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн Журам батлах тухай 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арваннэгдүгээр хуралдаанаас **ТОГТООХ** нь:

- 1.Хэнтий аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг “Үр дүн гарсан” гэж дүгнэсүгэй.
- 2.Энэхүү тогтоолыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхийг аймгийн Засаг дарга (Д.Аюурбунь)-д даалгасугай.

ДАРГА



Б.ЦОГТ-ОРШИХ